



УВС ЧАЦАРГАНА ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Увс чацаргана” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот БГД 3 хороо “Эн Би Би Ди” ХХК байр 2 давхар 2 тоотод болов.

Хуралд:

“Увс чацаргана” ХК нь нийт 713499 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч

С.Батболд/ 188300 ширхэг хувьцааны саналаар/

Д.Эрдэнэ /191109 ширхэг хувьцааны саналаар/

тус тус өөрийн биеэр оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 713499 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 379409 ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц 53,1 хувьтай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 13 цаг 20 минутанд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунсайн үг хэлэв.

-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Компанийн ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай тогтоолд хурлыг удирдах даргаар Д. Эрдэнийг томилсон иймээс хурлын дарга хурлыг эхлүүлнэ үү.

Ингээд хурлын дарга Д.Эрдэнэ байраа эзлэв.

- За та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Миний бие Увс чацаргана ХК-ийн ТУЗ дарга хувьцаа эзэмшигч Эрдэнэ гэдэг Ингээд хуралаа эхлэх үү. Хурлын дэгийг юуны өмнө уншиж танилцуулая.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт ;
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох ;
4. Бусад асуудал:

СОНССОН НЬ 1:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2022 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн товч танилцуулгыг уншиж танилцуулав. /Presentation/ ээр танилцуулга хийв.

“Увс чацаргана” ХК нь 1978 оноос хойш чацарганы үйлдвэрлэл эрхлэхээр байгуулагдсан бөгөөд 1988 он гэхэд нийт 480 га талбайд 500,000 ширхэг чацарганы модтой, бүрэн механикжсан усалгааны систем, үерийн далангийн байгууламжтай, нийт 300-аад ажиллагсадтай эрдэм шинжилгээний туршилт судалгааны төв болон өргөжсөн юм.

Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990-ээд оны үед тус байгууллага нь бусад аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн нэгэн адил зах зээлийн болон санхүүгийн хямралд өртөж их хэмжээгээр сүйдсэн юм.

Манай компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Чацарганы аж ахуй
2. Мод үржүүлэг
3. Төмс, хүнсний ногоо тариалалт зэрэг салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж байна.

Шинэчлэгдсэн компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь чацарганы аж ахуй юм.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Ариунсайн Компанийн тухай хуульд заасаны дагуу төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногын дотор ноогдол ашиг хувиарлах тухай шийдвэрийг ТУЗ гаргана гэж заасаны дагуу ТУЗ хуралдаж компани (2.544.216) төгрөгийн ашигтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хувиарлах боломжгүй гэж үзсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2022 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.
4. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.
 1. Д.Эрдэнэ
 2. Б.Болдбаатар
 3. С.Ариунсанаа
 4. С.Батболд
 5. М. Сайннямбуу
 6. Ц.Балжинням

5. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг
Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Б.Батдэлгэр
2. Б.Бат-Орших
3. Т.Өлзийбат

6. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж,
компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРАЛ УДИРДСАН:
ХУРЛЫН ДАРГА

 /Д.ЭРДЭНЭ/

ПРОТОКОЛ БИЧСЭН:

 /А.АРИУНСАЙН/